

ЯНПАЙН ТАЛААР НЭХЭН СУДЛАХАД

Д.Дашдулам

Ж.Наранчимэг

Товч агуулга: Энэхүү судалгааны өгүүлэгтээ XVIII-XX зууны үеийн Монголын түүх, соёлын хосгүй дурсгал болох “Муу бүхнээс хамгаалах халхавч хэрэм буюу “янпай”, “ямпай”-н талаар тогтоож өгүүлье.

Түлхүүр үг: Янпай, ямпай, халхавч хэрэм, Чойжон ламын сүм, Манжийн хаан, Олноо Өргөгдсөн Богд хаант Улс, Төрийн Чойжон Лувсанхайдав, Үхэшгүй мөнх найман сахиус, Хонсим бодьсадва.

Янпай гэдэг үгийн талаар товчхон боловч тайлбарлахад, хятад хэлний “yingbi” (影壁) хэмээх үгнээс гаралтай бөгөөд судлаачид ихэвчлэн “халхавч хаалга”, “халхавч хэрэм” хэмээн янз, янзаар тайлбарласан нь олонтой. Мөн “zhabi” хэмээн нэрлээд “хаалт хана”¹ гэсэн нь ч тааралддаг.

Янпайг чулуун хавтан тоосгоор урлаж ордон, сүмийн өмнө хэсэгт босгосон нь нэг талаар самбар тэмдэг гэлтэй.

Хэдийгээр Дорно дахин болон Хятад “yingbi” (影壁)² хэмээн дуудагдах авч Монголд “Янпай” (Yanpai) хэмээн нь хэлэгдэн заншжээ.

Харин Yanpai хэмээх үг нь хятад хэлний Yan-чулуун, pai- пайз, самбар хэмээх үг бөгөөд урьд нь чулуун самбар, хөшөөг нэгэнтээ нэрлээд заншсан байсантай адилаар “янпай” хэмээн “Халхавч хэрэм”- ийг нэрлэх болжээ. Энэ нь нэг талаар монголчууд тогтсон хэллэгийн өөрчлөлгүйгээр шууд хэрэглэх болсон нөгөө талаар монголчууд дуудлагыг чухалчилгүйгээр адилхан чулуун самбар, тэмдэг хэмээн хүлээн авч “Янпай” хэмээн нэрлэн дуудан заншсан болов уу хэмээн үзэж байна.

Өөр нэгэн харгалзан үзэх зүйл бол Монголчууд нь нүүдлийн соёл иргэншилтэйн хувьд “Yingbi” болон “Yanpai” хоёрын ялгааг төдийлэн чухалчилалгүйгээр зөвхөн түрүүлж хэвшсэнээр нь “Yanpai” чулуун пайз, самбар хэмээх утга тогтон хэвшигдсэн бололтой. Чухамдаа яг хэдий үеэс эхлэн тогтож хэлэгдсэн гэдэг нь тодорхой бус ч гэлээ бидний үзэж байгаагаар

¹ З.Оюунбилэг “Амарбаясгалант архитектур” УБ 2010 ., тал-42

² Хятад Монгол толь. Хөх хот 1982., тал- 1941

Манжийн үеэс “Янпай”-г босгох үеэс эхлэн “Yingbi” гэдэг нь орхигдон чулуун самбар, тэмдэг хөшөөнүүд бүхэлдээ “Yanpai” албан ёсоор нэрлэгдэх болсон хэмээн бодож байна.

Бидний үзэж байгаагаар Монголчууд “Янпай” гэдгийг “Халхавч” , “хаалга”, “Хана, Хаалт” хэмээн ойлгож, ярьж, бичсээр ирсэн боловч цаашид “Хамгаалагч халхавч хэрэм” гэж үзэх нь илүү бодитой гэх саналыг дэвшүүлж байна.

Энэхүү “Янпай” –н дурсгалыг язгуур эх соёл болох Хятад болон Дорно дахины бусад орны “ Янпай”-тай харьцуулахад энэ нь яахын аргагүй бэлгэдэлийн гүн агуулга бүхий “ Хамгаалагч халхавч хэрэм” гэж үзэхэд хүргэж байна.

Нөгөөтэйгүүр энэ нь ердийн нэгэн “хаалт, халхавч, хаалга, хана” гэж үзэх нь ихээхэн учир дутагдалтай, оноогүй тайлбар бөгөөд харин Дорно дахины ард түмнүүдийн шашин шүтлэг, соёлд нийтлэг байдаг муу бүхнээс хааж хамгаалан, хайцаалан зайлуулах ид шид, дом, шившлэг зэрэг гүн утга санааг цуллагаар агуулсан “ Хамгаалагч халхавч хэрэм” гэж үзэх нь илүү оновчтой юм.

Одоогоор мэдэгдэж байгаагаар Монгол улсад гурван томоохон хийд, орд өргөөний өмнө “Янпай” дурсгал сүндэрлэн байна. Тухайлбал, Найралт төв хаанаас Өндөр гэгээнд зориулан босгосон “Амарбаясгалант хийд” (1727)³ , Нарангэрэлт түмэн наст VIII Богд хааны орд өргөө” (1893)⁴, “Өршөөлийг хөгжүүлсэн сүм” буюу бидний мэдэх “Чойжон ламын сүм” (1904-1908)⁵-ийн өмнө сүр хүчийг илтгэн оршоор байгаа билээ.

Өөр нэгэн анхаарал татсан зүйл бол “Хамгаалагч халхавч хэрэм” буюу “Янпай”-г Манжийн хааны зарлигаар соёрхогдон батламжлагдсан бүх сүм, хийд, орд өргөөний өмнө бус зөвхөн дээрх гурван сүм, хийд, орд өргөөний өмнө босгосон нь тохиолдолын бус зүйл гэж үзэж байна.

“Янпай”-н гарал үүслийг нь авч үзвэл “Хамгаалагч халхавч хэрэм” нь эртний хятадын Жоу (Zhou) (МЭӨ11 зуун- МЭӨ771)-ийн үед мод, чулуу, тоосго хавтан зэргээр хаад, ихэс ноёдын орд, өргөө сүмийн өмнө барих болсон байна.

Одоогоор мэдэгдсэнээр хамгийн урт, том, уран тансаг хийцтэйгээрээ алдартай “халхавч хэрэм” нь Мин улсын үед баригдсан Бээжингийн Бэйхай цэцэрлэгт хүрээлэнгийн хойд хэсэгт байх 45м урттай янпай ажээ.

³ З.Оюунбилэг., Амарбаясгалантын архитектур., УБ., 2010., тал., 27

⁴ О. Намнандорж., III боть., УБ., 2005., тал., 480

⁵ МҮА., М-85.Д-2.1062 Чойжон ламын сүмийн данс нугалбар

Уг халхавч хэрэм нь шигтгэмэл өнгөт хавтан дээр мушгиралдсан есөн лууг дүрслэхийн хамт хэрмийн дээвэр нурууг 635 жижиг луугаар чимэглэсэнээрээ ихээхэн гоёмсог, алдартай хэмээн үздэг юм.

Ерөнхийд нь авч үзвэл халхавч хэрмүүдийн нийтлэг тал нь бүгд цогцолбор барилгаас тусдаа тусгаар, сүм хийд, орд өргөөний гол хаалганы чанх урд тусгаар голлон орших бөгөөд элдэв муу муухай, аюул зэтгэр, гай тоггороос хамгаалан сайн сайхан, ариун эрхэм бүхнийг урин бэлэгдсэн уран барилгын гайхамшигтай хосгүй дурсгал юм.

“Янпай” нь тухайн орд өргөө, сүм, хийд болон харьяалсан эзэнг нь бусдаас онцгойлон ялгаруулан тодотгож нөгөөтэйгүүр тэдний нийгэмд эзлэх байр суурь, зэрэг, дэв, нөлөөг илэрхийлдэг. Хэдийгээр Монголын томоохон сүм, хийдүүд нь Манжийн хаанаас зөвшөөрөл, батламж нэр авч байсан авч бүгд “Янпай” буюу “Хамгаалагч халхавч хэрэм” босгосон нь үгүй. Үүнээс харахад зарлигаар зөвшөөрөгдсөн сүм хийдүүдээс ялгаатай төдийгүй онцгой гэдгийг “Янпай” давхар батлаж байна.

“Янпай”-г дагалдаж Монголчуудын дунд тогтсон өөр нэгэн хэв ёс бий болсон нь энэхүү орд өргөө, сүм хийд нь Манжийн хааны сүр хүч, соёрхол ивээлд буйг сануулах тул зочид болон энгийн, явуулын хүмүүс бие бэлдэн хүндэтгэл үзүүлэн тухайн сүм, хийд орд өргөөний тогтсон ёс журмыг чанд хатуу даган мөрддөг байжээ. Тухайлбал, янпай бүхий сүм хийдийн халхавч хэрэмийн өмнө болон хойно хэсэгт хөл хоридог байсан байх бөгөөд сүмд ирэгсэд нь хөл хорисон хайс шөргөөгийг тойрч тусгай зассан морины уяанд морио уяхаа зэрэг тогтсон журам, хэв хууль байсны ул мөр өдгөө буй бөгөөд энд дэлгэрэнгүй өгүүлэх нь илүүц бизээ.

Үүнээс харахад “Янпай” нь нэг ёсны бүгдэд ил тодоор мэдрүүлсэн шашны болон зарлигаар тогтоосон батламж, пайз тэмдэг гэлтэй.

Нөгөөтэйгүүр тэрхүү “Янпай” буюу “Хамгаалагч халхавч хэрэм” нь аливаа сүм хийдэд морилогч хэнбугайн ч элдэв муу муухай, бодол санаа, ариун бус явдлыг шүүн ариусгахын дээр сүм орд өргөөг “халхавчлан хамгаалдаг” гэсэн ойлголтыг нийтэд нэвт суулгаж өгчээ.

Тиймээс ч энэхүү ойлголт нь хожим гүн бат тогтон уламжлагдан янпай бүхий сүм, хийд, орд өргөөг ариун, догшин, хамгаалттай гэсэн далд санааг олон түмний дунд нэвт суулган ороо бусгаа элдэв зүйлээс “хамгаалсаар” өдгөө оршин ирснийг “Янпай”-тай холбон тайлбарлах нь ч бий.

Бидний мэдэж байгаагаар Монголд байгаа эдгээр “Хамгаалагч халхавч хэрмүүд”-ийн хамгийн эртнийх нь “Амарбаясгалант хийд” бөгөөд удаах нь VIII Богд Жибзундамба хутагтын, хамгийн сүүлийнх “Чойжон ламын сүм”-ийн ямпай болно. “Чойжон ламын сүм” буюу “Өршөөлийг хөгжүүлсэн сүм” нь XX зууны эхэн үед бүтээгджээ.

Хамгийн эртнийх хэмээн үзэж байгаа “Амарбаясгалант хийд”-ийн “Янпай” буюу “Хамгаалах халхавч хэрэм” нь 16х9м хэмжээтэй бөгөөд бусад хоёр Янпайтай ч адил хэмжээтэй байгаа нь сонирхолтой.

Харин хийц, өнгө, чимэглэлийн хувьд бүгд өөр, өөр байдаг. “Чойжон ламын сүм”, VIII Богд Жибзундамба хутагтын орд өргөөний өмнө байх “Янпай” нь хөх саарал өнгөтэй бол “Амарбаясгалант хийд”-ийн “Янпай” нь зосон улаан өнгөтэй ажээ.

Анхаарал татаж байгаа зүйл бол хэмжээний хувьд бүгд ойролцоо буюу 16х9м байгаа бөгөөд уртын хувьд бүгд 16м бололтой. Харин өндөрийн хувьд нарийвчлан гаргасан хэмжээс одоо хүртэл байдаггүй тул судлаачид цаашид анхаарууштай.

“Амарбаясгалант хийд”-ийн “Янпай”-г 16х0.92м⁶ хэмжээстэй гэсэн нь ташаарсан бололтой. “Чойжон ламын сүм”-ийн “Янпай” нь 16х9м орчим ажээ.

“Янпай” –н бэлгэдэл, дүрслэлийн талаар хэдэн зүйлийг өгүүлье. Тухайлбал, “Амарбаясгалант хийд”-ийн янпайн нүүрэн талд ваартай дэлгэрч буй дөрвөн цэцэг, түүний дээр дөрвөн тоть шувууг товойлгон пааландаж дүрсэлсэн байдаг. Дэлгэрч буй цэцэг нь дөрвөн улиралыг, ваар нь амар амгаланг илэрхийлж, өөрөөр хэлбэл “дөрвөн улиралд амар тайван байхыг” бэлэгдсэн. Мөн дэлгэрч байгаа цэцэг нь одоо үеийг цомирлогоо дэлгээгүй цэцэг нь дараа үе буюу “үр удам хэзээ ч тасрахгүй” гэсэн утгатай⁷ хэмээн тайлбарласан байдаг.

Мөн судлаач, “Янпайн ар талд байх зөрсөн хоёр лууг мөн товойлгон паалантай ваараар дүрсэлсэн. Хааны зарлигаар байгуулсан учраас хаан эзний сүр хүчийг илэрхийлэн хоёр лууг “арга билэг”-ээр дүрсэлсэн байна” гэжээ.⁸

Бидний үзэж байгаагаар дэлгэрч буй цэцэг нь Дорно дахины улсуудад түгээмэл дэлгэрсэн урт удаан нас, мөнхийн бэлгэдэл бөгөөд уг сүмийг “мөнх мандан бадарч, хөгжин дэлгэрч” байхыг бэлэгдэн дүрсэлсэн хэмээн үзэж байна. Харин бусад бэлгэдэл, чимэглэлийг Дорно дахины соёлтой холбон уялдуулан үзэж тайлбарлавал зохилтой.

“Янпай” дээр савраа дэлгэн тэнгэрт мандсан хос лууг дүрсэлсэн нь тухайн үеийн Манж Дайчин улсын хаант төрийн бэлгэгдэл сүр хүчийг, нөгөө талаар хийдийг хааны ивээл зарлигаар баригдсанг, өндөр зэрэг дэв бүхий язгуур гаралтай хүнд зориулсан босгосон болохыг давхар илтгэж байгаа болно. Гэхдээ Манж Дайчин улсын хаант төрийн бэлгэгдэлийг дүрсэлсэнээрээ Манж Дайчин улсын сүр хүчийг бүгдэд мэдрүүлэн бишрүүлэх гэсэн далд санаа агуулагдаж байсныг үгүйсгэх аргагүй.

⁶ З.Оюунбилэг., Амарбаясгалантын архитектур., УБ., 2010., тал., 42

⁷ Мөн тэнд

⁸ Мөн тэнд


Нарангэрэлт түмэн наст VIII Богд хааны орд өргөөний өмнөх Янпайн талаар эрдэмтэн Ж.Өлзий абугай Монголын дурсгалт уран барилгын түүхээс” хэмээх бүтээлдээ цухасхан дурдсан байдаг.

Уг бүтээлд, ... Богд хаан, хатан хоёрыг хүндэтгэн хос луу ороолгон тойруулж, Монгол орны байгалийн баялаг, уул усыг төлөөлүүлэн зурж, шарын шашныг мандуулах үйл хэрэгт тохиолдох элдэв хор хөнөөлийг сэргийлэн үүрд жаргал, цэнгэлээр тэгш амьдрахыг бэлэгдэн байгуулжээ⁹ гэсэн нь анхлан тайлбарласнаараа сайшаалтай хэдий ч хуумгай дүгнэлт болжээ.

Тухайн үеийн Дорно дахины ард түмний соёл, уламжлал, шашин шүтлэг тэр дундаа Манж Чин улсаас эрхшээлдээ байсан улсуудад явуулсан бодлого, Манж Чин улсын төрийн ёс, бэлгэдэл зэргийг хоршуулан үзэхэд дээрхээс өөрөөр тайлбарлаж болох.

Зохиогч ороолгон тойруулсан хос лууг Богд хаан, хатан хоёрыг хүндэтгэн үзсэний илэрхийлэл хэмээн үзсэн нь хэтэрхий өрөөсгөл, амьдлаг бус тайлбар юм.

Нөхцөл байдлаас харахад тухайн үед Манжийн төрөөс Богд хаан, хатан хоёрыг хүндэтгэн үзсэндээ дээрх дүрсийг бүтээсэн бус Манж Дайчин улсын төрийн бэлгэдэл хос луугаар Манжийн төрийн сүр, дийлэгдэшгүй хүч чадал, Манжийн төрийн ивээлд буйг, мөн ордоны өндөр зэрэг дэв, эрх дархтай болохыг бусад орд өргөө, сүм хийдээс тодотгон босгожээ. Өөр олон талаар ч тайлбарлахыг үгүйсгэхгүй.




VIII Богд хааны ордоны өмнөх Янпай

⁹ Ж.Өлзий., Монголын дурсгалт уран барилгын түүхээс., УБ., 1992., тал., 31

Ер нь Манжийн төрийн сүр хүч, дийлэгдэшгүй хүч чадлыг илэрхийлэл анхнаасаа тэнгэрийг эзэлсэн хос лууг байсан бөгөөд лууны дүрс бүхий торго, эд, эдлэлийг хэн дуртай нь эдлэж хэрэглэдэггүй зөвхөн дээд тэнгэрээс язгуур, заяатай хаан, түүний удмынхан л хэрэглэдэг байсан юм.

Мөн “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын хууль зүйлийн бичиг”-т тэмдэглэсэнээр язгууртан ноёдын зэрэг, дэв, хэргэмийн пүсү тэмдэгт, хаан эзэн төрөл угсааныхан таван хумст лууг хэрэглэх¹⁰ бөгөөд лууны саврын хумсны тоогоор язгууртан ноёдуудын зэрэг дэв тодорхойлон заасан байх ажээ. Үүнээс үзэхэд Богд хааны ордоны өмнөх Янпай дээрх таван хумст хос луу нь түүний зэрэг дэв буюу ордоньг эзэмшигчийн өндөр дээд угсааг илтгэж байна. Мөн “Амарбаясгалант хийд”-ийн янпайн хос мандсан лууны тайлбарын агуулгатай утга дүйцэнэ хэмээн үзэж байна.

Гуравдах буюу он цагийн хувьд хожуу үед хамаарагдах “Төрийн Чойжон Лувсанхайдавын сүм”-ийн Янпай нь нөгөө хоёроосоо хэлбэр хийцийн хувьд илүү уран тансаг чимэглэл, өргөн утга агуулгатай нь ихээхэн анхаарал татдаг.




“Чойжон ламын сүмийн Янпайн гол хэсгийн нүүрэн талд байх Хангард шувуу, хоёр цагаан барсын хамт

¹⁰ Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах хууль зүйлийн бичиг., Хөх хот 1989, доод дэвтэр., хувцас заслын тухай зүйлүүд

“Чойжон ламын сүм”-ийн “Хамгаалах халхавч хэрэм” нь адилхан хэмжээс бүхий 16м урт, 9м өндөртэй бөгөөд хэрмийн өмнө нүүрэн талд ертөнцийн дөрвөн хүчтний нэг болох Хангарьд шувууг цаст уулын хоёр цагаан барсын хамт гол хэсгийн хавтаст дүрсэлжээ.

Мөн гол хэсгийн дээд өнцгүүдэд үлгэр домгийн шидэт галт шувууг өөд, өөдөөс нь харуулан чимэглэж, доод хоёр буланд нь бурханы шашин ариун байхын билэгдэл болох цомирлогоо дэлбээлсэн бадамлянхуа цэцгээр хээлсэн байх ажээ.




Урт удаан мөнхийн билэгдэл болох ланз үсэг

Янпайн нүүрэн талын зүүн, баруун хоёр хавтаст Дорно Дахины орнуудад түгээмэл шүтэгдсэн “Үхэшгүй найман сахиус”-ыг дөрөв, дөрвөөр нь дүрслэхийн хамт дээд болон доод хэсгийн голд нь “урт удаан, мөнх” гэсэн билэгдэл бүхий ланз үсгийг шигтгэж, луун хээгээр гоёмсог чимэглэсэн байна.

Янпайн хоёр талын хавтсан дээр дүрслэгдсэн дээрх найман хүмүүсийн талаар одоо хүртэл тайлбарлан судалсан зүйл огт таарсангүй. Магадгүй энэ нь өнгөрсөн хугацаанд иргэдээ шашингүйн үзлээр “хүмүүжүүлэн” шашны талаарх уламжлал, зан үйлийн талаар ярьж, бичих нь хориотой байсантай холбоотой төдийгүй нөгөө талаар бодит үнэн мартагдан бүдгэрчээ.

Ямпайн хоёр талын хавтсан дээрх эдгээр найман хүмүүсийг Хятадын үлгэр домогт “Үхэшгүй мөнх найман сахиус” хэмээн нэрлэх бөгөөд хүн тус бүрийн хүч нь чөтгөрийг устгах, амилуулах, амьдрал бэлэглэх чадалтай гэх тодотголоос гадна хамтад нь “нууцат үхэшгүй найм” хэмээн нэрлэх ажээ.



**“Чойжон ламын сүм”-ийн Янпайн баруун талын хавтаст байх
“Үхэшгүй мөнх найман сахиус”-ын дөрөв (баруун талаас Лю Донгбин, Ли
Тайгу таягтай, Эзэн хааны авга гэх Као, Лан Кайхи)**

Тэдний ихэнх нь Тан болон Сүнгийн үед амьдарч байсан бодит хүмүүс бөгөөд өөр, өөрийн гэсэн домогтой. Эдгээр хүмүүсийн талаар зарим нэгэн зүйлийг товчхон өгүүлье.

“Үхэшгүй мөнх найман сахиус” нь үхэшгүй эмэгтэй Хи, Эзэн хааны авга ах Као, төмөр таягт Ли, Лан Кайхи, Ахлагч Лүю Донгбин, Философич Хан Кианг, Өвгөн Занг Гуо, Хан Зонгли нар болно.

Тэдний тус, тусын эрдэм чадал нь үхэшгүй мөнхийн байж, агуу хүч чадлыг бий болгож, бүхнийг дийлэгч, гайхамшигийг бүтээдэг хэмээн домоглогдсоор иржээ.

Тиймээс дээрх домгийн баатруудыг сүм хийдийн өмнө хэсэгт бэлэгдлийн утга агуулан Янпайд дүрслэх болсон нь санамсаргүй хэрэг биш.

Хятадын урлаг, уран зохиол болон Дао шашны дунд түгээмэл дэлгэрэн шүтэгдэх болсон шидэт найман хүмүүс нь Бохайн арал дээр амьдардаг хэмээн уламжлагдан яригдсаар иржээ.



**“Чойжон ламын сүм”-ийн Янпайн зүүн талын хавтаст байх
“Үхэшгүй мөнх найман сахиус”-ын дөрөв (баруун талаас эмэгтэй Хи,
лимбэтэй Хан Хиан, хөгшин Занг Гуо, Зонгли Кюүан)**

Дао шашны “Үхэшгүй мөнх найман сахиус”-ыг дүрсэлсэн дурсгалууд нь Хан улсын үед хамаарах бөгөөд хамгийн анх дүрслэгдсэн нь Жин улсын үе буюу Алтан улсын үе (1115-1234)-д хамаарагддаг. Үүнээс харахад XII-XIII зууны үеийн Жингийн булш бунханы чимэглэл, ханийн зурагт дүрсэлсэн уран барималууд нь зөвхөн Алтан улсаар хязгаарлагдахгүй Азийн улс орнуудад түгээмэл шүтэгдэн гүн бат, тархсан байдаг. Үүнийг зөвхөн Хятадын соёлоор хязгаарлавал өрөөсгөл бөгөөд болохгүй мэт санагдана.

Хятадын хувьд “Үхэшгүй мөнх найман сахиус”-ыг дүрсэлсэн хамгийн алдартай нь Рүйчинг дэхь “Мөнхийн баясгалант сүм” юм. “Үхэшгүй мөнх найман сахиус”-ыг хөгжил цэцэглэлт, урт удаан, мөнх оршихын билэгдэл хэмээн үздэг учраас эртний урлагт өргөн дүрслэгдэг байв.

“Үхэшгүй мөнх найман сахиус”-ыг зөвхөн дүрслэх урлаг төдийгүй уран зохиол, жүжиг, түүх бичлэгээс харж болно. Тухайлбал, Лүю Донгбины хэрхэн Зонглитай учирч Үхэшгүй мөнхийн замаа эхэлсэн тухай домог¹¹ нь Хятад

¹¹ Stephen Little: “Taoism and the Arts of China” pp., 313, 319-334. The Art Institute of Chicago, 2000

Юаны үеэс олон янзаар бичигдэн улмаар хэд, хэдэн жүжиг болон дэлгэрсэн нь одоо хүртэл олны дунд алдартай хэвээрээ байна.

“Үхэшгүй мөнхийн найман сахиус”-ыг төлөөлүүлэн Төмөр таягт Ли¹² буюу Тайгуай, Лүю Донгбин нарын талаар өгүүлье.

Төмөр таягт Ли буюу Ли Тайгуай

Төмөр таягт Ли нь найман сахиус доторх хамгийн эртнийх бөгөөд хамгийн алдартай нь билээ. Домогт өгүүлснээр найман их сахиус нь Хятадын зүүн хэсэгт орших усан онгоц үл гатлах гагцхүү тайван номхон үед л гарч болох Диваажин /Пенглай Шан/ хэмээх арал дээр амьдардаг аж.

Түүнийг ихэвчлэн төмөр таягтай, хулуу барьсанаар дүрсэлдэг. Хулуунаас нь заримдаа утаа мушгиран гардаг нь түүний сүнс биенээсээ чөлөөтэй гарч, орж байдаг чадал, хүчийг илтгэдэг. Мөн дутагдаж гачигдсан хүмүүст өгөх хоол унд, эм танаар дүүрэн байдаг гэж яригдан уламжлагджээ. Төмөр таягт Ли нь Юан улсын үед төрсөн ба жинхэнэ нэр нь Ли Юань ажээ.

Тэрбээр Дао шашныг үндэслэгч Лао Тзутай хамт суралцаж байсан бөгөөд дөчин жилийн турш эд баялагаас татгалзаж, хоол ундгүй хатуу бэрхээр агуйд амьдарсан гэдэг. Лао Тзу түүнийг шалгахаар шийдэж сайхан хүүхэн модоор хийж уруу татахыг оролдоход харин Ли хүүхний сайханд үл автан татгалзснаас гадна түүний өөшийн эсрэг тэмцэж эхэлжээ. Тиймээс Лао өөрийн заль мэхийг хэлж, нэгэн эмээр шагнасан нь хэзээ ч өвдөх, өлсөх зовлонгүй болгожээ.

Лао дахин мөнгөөр сорихоор өөрийн зүсийг хувилган Лигийн газарт очиж хулгайч нар мөнгө нуусныг хэлж авахыг зөвлөхөд “амьдралынхаа туршид ядуу хэвээр үлдсэн ч мөнгийг авахгүй хэмээн татгалзсан нь Лаог дахин уярааж тэрээр түүнд нэгэн шидэт эм өгсөнөөр гайхалтай хурдан нисэх чадварыг олжээ.

Төмөр таягт Ли нь үхэшгүй мөнх сахиус болохоосоо өмнө маш царайлаг залуу байжээ. Нэгэн удаа түүний сүнс диваажин луу бусад сахиустай уулзахаар аялах үедээ өөрийн шавьдаа сүнс эргэж иртэл 7 хоног хүлээ, хэрэв ирэхгүй бол биеийг шатаа, энэ нь үхэшгүй мөнх болсон гэсэн үг гэж хэлжээ.

Гэтэл шавь нь зургаан бүтэн өдөр хагас хоногийн дараа өвчтэй эхийгээ сүүлчийн удаа харахаар явах хэрэгтэй болж, биеийг нь яаравчлан чандарлажээ. Шавийг явах гэтэл үхэж буй гуйлгачин дайралдахад яарч байсан тул орхин оджээ. Лигийн сүнс буцан иртэл орж болох цорийн ганц бие нь үхэж буй гуйлгачин байлаа.

Ийнхүү Ли аргагүй байдлаас болж урт шовх ээмэг бүхий том чих, ноосорхог сэгсийсэн үс сахал, өндөр хэрзгэр бие, хар хөмсөг нүдтэй, доголон хөлтэй толгой дээрээ хоолны таг тавьсан гуйлгачингийн биед орж, ийм дүртэй

¹² The eight immortals by W. Perceval Yetts. Journal of the Royal Asiatic society of Great Britain and Ireland. London 1916., p-804

болсон байна. Дахин Лао Тзу гарч ирэн түүнд ямарч өвчнийг эдгээх эмийн хулуун домбо өгч, хийсэн тусыг үзэн үхэшгүй мөнх болгосон гэдэг.

Тэр цагаас хойш Ли өвчин зовлон байгаа газарт хүрч өөрийн тусыг хүргэх болжээ. “Үхэшгүй мөнх найман сахиус” нь хүн бүр хэрхэн үхэшгүй мөнх байдлыг олж болох жишээ бөгөөд үхэшгүй мөнх болоход бие болон оюун санааны бясалгал, хооллолт, дасгал, амьсгал, өвс ургамлыг хэрэглэдэг байна.

Лүю Донгбин¹³

Лүю Донгбин нь түүхэн бие хүн бөгөөд шашин болон бусад соёлын хүрээнд ихээхэн бишрэн шүтэгдсэн ба найман их сахиусын ахлагч гэж үздэг.

Лүю Донгбин нь “Сүн улсын түүх” хэмээх төрийн албан түүхэнд дурдагдсан байдаг. Түүнийг урлагийн бүтээлд нуруундаа чөтгөрийн сүнснүүдийг айлгах сэлэм зүүсэн эрдэмтэн хүний дүрээр дүрслэдэг. Заримдаа хөлчүүрхсэн байдлаар дүрслэдэг нь Дао шашны алдартай уран бүтээлчдийг сархад зооглох дуртай хэмээн үздэгтэй адил юм. Лүю Донгбин нь маш хурц зантай байсан бөгөөд залуу байхдаа уурласан үедээ голын урсгалыг өөрчилж байжээ. Лүю нь бүтээлч яруу найрагч байсан бөгөөд түүний уран бүтээлүүд нь Тан улсын бүрэн яруу найрагийн эмхтгэлд байдаг. Түүний жинхэнэ нэр Лүю Ян ба Ян нь түүний нэр, Донгбин гэдэг нь түүний эрхэмлэн хүндэтгэсэн нэр ажээ. Тэрээр Тан улсын үед 796 онд мэндэлжээ. Хүүхэд байхаасаа маш ухаалаг байсан тэрээр 20 насандаа хоёр ч удаа дээд түвшиний албаны шалгалт өгч албан хаагч болсон хэдий ч төдийлөн амжилттай олсонгүй.

“Шар будааны мөрөөдөл” хэмээх домогт өгүүлснээр нэгэн шөнө Лүю Ханданы зочид буудалд шар будаа болох зуур зүүрмэглэжээ.

Тэрбээр, эзэн хааны шалгалтыг амжилттай сайн өгч нэр хүнд, албан тушаалаар шагнагдан удалгүй зөвлөх сайд хүртлээ дэвшиж байна хэмээн зүүдэлж эхэлжээ. Тэгээд чинээлэг айлын охинтой гэрлэн хүү, охинтой болов. Хүмүүс түүний амжилт азанд атаархаж, Лүю гэмт хэрэгт буруутгагдан албан тушаалаасаа огцорч эхнэр нь урван, хүүхдүүд нь дээрэмчдийн гарт алагдажээ. Ийнхүү бүх баялагаа алдаж, гудамжинд үхэж байхдаа зүүднээсээ сэржээ. Хэдийгээр зүүд байсан ч гэлээ 18 жил өнгөрч бүх зүйл бодитоор будаа болох зуур болж өнгөрчээ.

Энэ бүх зүйлийг “үхэшгүй мөнх найман сахиус”-ын нэг Зонгли түр зуурын аз жаргал амжилтанд хэт их анхааралаа тавьж болохгүй гэдгийг ухамсарлуулах үүднээс хийжээ. Үүний дүнд Лүю өөрийн амьдралаа орхин Зонглитай хамт хорвоог таних Даог сэнхрүүлэн таниулахаар хамт явах болсон хэмээн үздэг байна.

¹³ The eight immortals by W. Perceval Yetts. Journal of the Royal Asiatic society of Great Britain and Ireland. London 1916., p-792

Дээрхээс харахад “Үхэшгүй мөнх найман сахиус”-нь ихээхэн утга санаа агуулахын хамт “Төрийн Чойжон Лувсанхайдавын сүм”-ийн “Хамгаалагч халхавч хэрэм” буюу янпай дүрслэлд байгаа нь ихээхэн сонирхолтой бөгөөд анхааран судлууштай.

“Чойжон ламын сүм”-ын “Хамгаалагч халхавч хэрэм” буюу янпайн нүүрэн гадна талын дүрслэгдэхүүнийг нэгтгэн авч үзвэл Ертөнцийн хүчтэн хангарьд, цаст уулын барс, Үхэшгүй мөнх найман сахиусын ид шид хүчээр хамгаалагдсан бөгөөд урт удаан мөнх оршин байх ашид мөнхийг бэлэгдсэн нь харагдаж байна.

Харин хэрмийн гол хавтсанд Тэнгэрийн луут Манж гүрний бэлгэдэл болох дөрвөн хумст таван лууг дүрсэлсэн нь сүмийн зэрэг дэв, эрх ямбыг харуулахын ялдамд хажуугийн зүүн, баруун хавтсанаа бурхны шашны агуулгыг илэрхийлсэн Хонсим бодьсадва, урт наст зургааг гайхалтай содон дүрсэлсэнээрээ онцлогтой.

“Хонсим бодьсадва гэдэг нь са: Bodhisattva Avalokitesvara буюу Арьяабал бурханы нэгэн дүр болно. Хонсим бодьсадва хэмээх нь энэ бурханы алдар бөгөөд хятад нэрний сунжирсан дуудлага болно.”¹⁴

Бид энэхүү өгүүлэгээрээ “Янпай” талаарх судалгааг нэгтгэн өгүүлэхийн ялдамд Олноо Өргөгдсөн Богд хаант улсын хаан VIII Богдын төрсөн дүү Лувсанхайдувын байгуулсан “Өршөөлийг хөгжүүлсэн сүм”-ийн өмнөх уран барилгын хосгүй дурсгал болох “Муу бүхнээс хамгаалагч халхавч хэрэм” буюу “Янпай” –н талаар тусгайлан тодруулах оролдлогыг анх удаа хийлээ.

Энэхүү янпайн талаарх одоо нийтэд тайлбарлагдаж байгаа тайлбар, хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдэд төдийлэн тодорхой бус, ташаа мэдээлэл байгаа нь судалгааг цаашид дахин цогц маягаар зайлшгүй хийх шаардлагатайг харуулаад зогсохгүй “Янпай” хэмээх төр, шашин, уран барилга, соёлын хосгүй дурсгалыг онцгой хамгаалалтанд авч музейн тайлбар сэлтэд бодит мэдээлэлээр олон нийтэд хүргэхийг хүсч байна.

Энэ нь эх түүх, соёлын дурсгалуудаа хамгаалан, хойч үедээ өвлүүлж, үнэн зөвөөр тайлбарлан үлдээх нь судлаач бидний чин хүсэл юм.

Abstract: The topic of the present research work is related to the “yanpai” or “the gate protecting from all kinds of evil”, which is a unique part of Mongolia’s history and culture. Although throughout many years, there were various opinions concerning the function of the “yanpai” monument, including a “shield”, “gate” or “wall obstruction”, these views are far insufficient and wide. Authors propose that it would be more realistic to consider it as a “protective wall-shield” that has a deeply symbolic meaning and represents attributes so common for oriental religions and

¹⁴ Буддын шашин соёлын тайлбар толь., УБ., 2000., тал., 106

cultures such as charms that protect and insulate from evils, and magical remedies that dissipate the bad. As of today, "yanpai" monuments can be found in front of three sites, in particular the Amarbayasgalant monastery (1727), which was built by Nairalt Tuv Khan especially for Undur Gegeen, the palace of VIIth Bogd Khaan (1893), and the Mercy Evolving Monastery or, as known to many, the Choijin Lama Temple (1904-1908).

The "yanpai" distinguishes the palace, monastery/ temple or its owner from others, and at the same time, demonstrates the owner's position within the society, title and influence. The authors of the research made an attempt to summarize the studies on "yanpai" monuments, and, for the first time, present distinctive clarifications on the "yanpai" monument standing in front of the Choijin Lama Temple, which was built by Luvsankhaidav, brother of Mongolia's last ruler VIIIth Bogd Khaan.